

БЭЛЧЭЭРИЙН МЕНЕЖМЕНТ ТӨСЛИЙН НЭГЖ-ОНӨТҮГ-ЫН 2019 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ТАЙЛАН

Нэг. Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, үр дүн

Улсын болон нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа ажлын явц

Хөдөө аж ахуйн зориулалттай газрын ашиглалтыг сайжруулж, өрхийн тариаланг нэмэгдүүлэн, хөрс, цаг уурын онцлогт тохирсон таримлыг тариалуулж, бүтээгдэхүүний гарцыг нэмэгдүүлнэ.

Бэлчээрийн талбайд олон настын үрийн холимогоор тариалалт хийж, хөрсний чанарыг сайжруулах ажлын хүрээнд зарлагдах “Хөдөө аж ахуйн техник, тоноог төхөөрөмж хадгалах байр барих” ажлын тендерийн бичиг баримт боловсруулах;

- Уг ажлын тендерийн бичиг баримтын төслийг боловсруулан Нийслэлийн хөрөнгө оруулалтын газарт 3 дугаар сард хүргүүлсэн. Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газраас уг тендерийг 3 удаа зарласанаас эхний 2 удаад ямар нэг компани оролцоогүй. Харин 3 дахь удаад нэг компани оролцсон боловч сонгон шалгаруулалтанд тэнцээгүй. Сүүлийн сонгон шалгаруулалтыг 11 дүгээр сарын 29-ний өдөр зарлаж, 12 дугаар сарын 4-нд нээлт хийж дүгнэн, Суврага Өндөр компани шалгарч, мэдэгдэл хүлээн авсан. Одоо гэрээ байгуулах шатанд ажил явагдаж байна.

- Өнгөрсөн жилийн 4 дүгээр сард туршилтын 150 га талбайн дотор болон гадна талаас авсан хөрсний 6 дундаж дээжинд ХААИС-ийн Агроэкологийн сургуулийн Хөрс, агрохимийн лабораторт шинжилгээ хийлгэхэд дараахь үр дүн гарсан. Үүнд:

- Хөрсний ялзмагийн агууламж 2.76%-аас 3.99% болж 1.23 %-аар нэмэгдсэн.
- Хөрсөн дэх шим тэжээлийн элементүүд 100 гр хөрсөнд нитрат азот /NO₃/ 1.65 мг-аас 3.19 мг болж 1.54 мг-аар, фосфор /P₂O₅/ 1.6 мг-аас 2 мг болж 0.4 мг-аар, кали /K₂O/ 34 мг-аас 54 мг болж 20 мг-аар тус нэмэгдсэн.

Хөрсний урвалын орчин орчин /pH/ 6.2-оос 6.3 болж өөрчлөгдсөн нь сул хүчиллэгээс саармаг болж, ургамал ургахад тохиромжтой орчин бий болсон.


Туршилтын 150 га талбайн болон ойр орчмын хөрс дунд шавранцар буюу хүнд механик бүрэлдэхүүнтэй хөрс нь дулаан болон агаарын горимоор тааруу, агааржилт сул, хавар орой бүлээцдэг хүйтэн хөрсөнд хамаарч байгаа ба харин нарийн сүвшилтийн нийлбэр ихтэй хөрс байгаа нь тэнд ус тогтож, усны горимоор ургамал ургахад тааламжтай нөлөө үзүүлдэг болох нь харагдаж байна. Үүнтэй

уялдуулан тариалах хугацааг тооцоходоо тухайн жилд орох хур тунадасны хэмжээ болон хөрсний чийгийн хангамжтай уялдуулах шаардлагатай гэсэн дүгнэлтэд хүрсэн болно.

Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт

1.3.3 Мал аж ахуйг эрчимжсэн цогц байдлаар хөгжүүлэн, сүү, махны фермерийн аж ахуйд дэмжлэг үзүүлэх замаар нийслэлийн хүн амын сүү, махны хэрэгцээг дотоодын бүтээгдэхүүнээр хангана.

Бүгд Найрамдах Австри улсад үйлдвэрлэсэн "NATRO" холимог үрийг Бүгд Найрамдах Хятад ард улсаас 2016 онд оруулж ирсэн 2 төрөл 6 зүйл ургамлын холимог үртэй харьцуулсан үрийн өрөнхий шинжилгээ, стрессийн шинжилгээг ХААИС-ийн АгроЭкологийн сургуулийн Хөрс агрохимиийн лаборатори болон Био-Экологийн хүрээлэнгийн Хөрс ургамлын лабораторт тус тус хийлгэсэн. Шинжилгээний үр дүнд үрийн чанар 50%-иас дээш гарсан. Үүнтэй уялдуулж ногоон тэжээлд зориулж үетэн болон буурцагтан ургамлаас бүрдсэн 2 төрлийн 8 зүйлийн 21 сортын "NATRO" олон наст ургамлын үрийн холимгоор туршилтын талбайн өнгөрсөн жил хадалт хийсэн 6 га талбайд үрийн нормыг ихэсгэж, 1 га-д 25 кг-аар тооцож тариалалтын ажлыг 5 дугаар сарын 2 дугаар арав хоногт багтаан хийж гүйцэтгэсэн.



Фермийн ойролцоо малчин өрхүүд болон өөрсдийн үнээ, малаас гарсан өтөг бууцыг ашиглан 100 тонн органик бордоо бэлдсэн. Туршилтын 150 га талбайд хийлгэсэн хөрсний агрохимиийн шинжилгээний дүнг харгалзан бордох талбайг

сонгож, 5 га газарт бууц цацаж, 10 га талбайг компост бордоогоор бордсон. Мөн тариалалт хийгдээгүй 12 га газрыг намар бууцаар бордсон. Ирэх 2020 оны намар органик бордоогоор бордсон талбайн хөрсний шинжилгээг авч, хөрсний ялзмаг болон, тэжээлийн бодис хэрхэн нэмэгдсэн талаар харьцуулсан судалгаа хийнэ.

Өнгөрсөн жил тарьсан "NATRO" олон наст ургамлын холимог үрийг манай оронд нутагшсан бусад тэжээлийн олон наст ургамлын холимог үртэй харьцуулсан туршилтын ажлыг үргэлжлүүлж, ажиглалт судалгаа хийхэд тариалалт хийх хугацаанд хур тундас бага орсноос хамаарч илт ялгарсан үр дүн гараагүй.




2018 тарьсаны дараа




2019 оны байдлаар

Тайлангийн хугацаанд нийт тариалалт хийсэн 80 га талбайгаас сонголт хийж, өвс ургамлын гарц илүү 15 орчим га талбайгаас өвс хадаж, 500 кг жинтэй 11 ширхэг рулон боодол /нийт 5,5 тонн/ вакумжуулсан ногоон тэжээл хураан авч, 12 дугаар сараас эхлэн саалийн 3 үнээ сонгон, энэхүү ногоон тэжээлээр тэжээж, сүүний гарц хэрхэн нэмэгдэж байгаа туршилтыг эхлүүлсэн.



Дорнод аймгийн Матад суманд 60 га талбайд хадлан хийж, 15 кг жинтэй 2100 боодол буюу нийт 31 тонн өвс хураан авч, өвөлжилтийн бэлтгэл ажил хангасан.



Байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа техник, тоног төхөөрөмжүүдийн байнгын бэлэн байдлыг хангах зорилгоор Урсгал засварын болон Агротехнологийн төлөвлөгөөг боловсруулан батлуулж, мөрдөж ажиллаж байна. Фермийн үйл ажиллагаа болон өдөр тутмын ажлыг тогтвортжуулан автомат саалтуурыг туршиж байнгын ажиллагаанд оруулсан. Тайлангийн хугацаанд нийт 23 үнээ тугалж, нийт 11500 орчим литр сүү нийлүүлсэн.

Тогтоол шийдвэрийн хэрэгжилт, үр дун

Засгийн газрын 258 дугаар тогтоол, мөн 2019 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн хуралдааны тэмдэглэлээр өгсөн үүргийн хүрээнд байгууллагын цаг бүртгэлийн төхөөрөмжийг нийслэлийн erp.ulaanbaatar.mn систем ашиглан бүрэн холбож, албан хаагчдын цагийн бүртгэл, ажлын цагийн ашиглалтад хяналт тавих боломжийг бүрдүүлэх ажлыг байгууллагын хэмжээнд зохион байгуулж, байгууллагын удирдлага цагийн бүртгэлийн төхөөрөмжид ажлын цагийг бүртгэж, ажилласан.

Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах талаар байгууллагын Дотоод журам болон Ёс зүйн дүрэмд нэмэлт заалтууд тусгасан. Тайланийн хугацаанд байгууллагын хэмжээнд ажлын болон ажлын бус цагаар согтууруулах ундаа хэрэглэх явдал болон галт болон хүйтэн зэвсэг, тэсэрч дэлбэрэх болон шатамхай бодис, хэрэгслийг нэвтрүүлэх зэрэг үйлдэл илрээгүй болно.

Ажлын байран дахь бүх хэлбэрийн хууль бус дарамт шахалт, ялгавартай хандах үйлдлийн талаар байгууллагын дотоод журамд тусган ажилласан ба ажилтнуудын дунд эерэг уур амьсгалыг бүрдүүлэх зорилгоор сард нэг удаа хамт олноороо ууланд алхах болон төрөл бурийн уралдаант, хөгжөөнт тоглоом зохион байгуулах ажлыг уламжлал болгосон.

Байгууллагын үйл ажиллагааны үр дун

Нийслэлийн өмчийг эзэмшүүлэх гэрээний биелэлтийг Өмчийн харилцааны газраас шалгаж, дүгнэн 90 оноо авсан. Байгууллагын 2018 оны санхүүгийн тайланд Дундманхайдай аудит ХХК-аар болон Нийслэл дэх төрийн аудитын газраар аудит хийлгэж, “Зөрчилгүй” гэсэн дүгнэлт авсан. Байгууллагын 2016, 2017, 2018 оны Сүхбаатар дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсээс санхүүгийн шалгалт хийж, мөн “Зөрчилгүй” дүгнэлт авсан. Байгууллагын 2019 оны батлагдсан төсвийн хүрээнд зардлын хэтрэлтгүй, хэмнэлттэй ажилласан.

Иргэн Ц.Мажигсүрэнгийн хүсэлтээр 1 га талбайд олон наст таримал тариалах ажил гүйцэтгэж байгууллагад тодорхой хэмжээний орлогыг бүрдүүлэв. Мөн Дорнод аймгийн Матад суманд 60 га талбайд хадлан хийж, 15 кг жинтэй 2100 боодол өвс буюу нийт 31 тонн өвс хураан авч, өвөлжилтийн бэлтгэл ажил хангасан.

“Нутаг академи ТББ”- тай хамтран үнээний зохиомол хээлтүүлгийн техникч бэлтгэх 10 хоногийн сургалтыг 06 дугаар сард амжилттай зохион байгуулсан. Мөн дээрх сургалтанд хамрагдсан 15 хүнд болон ойр хавийн малчин фермер өрхүүдийн

төлөөллөөс бүрдсэн 15 хүнд байгууллагынхаа үйл ажиллагааг танилцуулж, хөдөө аж ахуйн чиглэлээр сургалт зохион байгуулсан.

Хүний нөөцийг чадавхижуулах талаар

Байгууллагын нийт албан хаагчдаас санал авч, сургалтын хэрэгцээг тодорхойлж, Сургалтын болон Нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг боловсруулж, батлуулсан. Тайллангийн хугацаанд “Төрийн албан хаагчийн хөдөлмөрийн харилцаа” сэдэвт сургалт зохион байгуулж, нийт албан хаагчид хамрагдан, уг сургалтанд 500.000 төгрөг зарцуулсан. Мөн Хөдөлмөр хамгаалал Хүний Хөгжлийн Төв мэргэжлийн байгууллагаас Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, Гал түймрээс урьдчилан сэргийлэх болон Анхан шатны тусламж үзүүлэх талаар сургалт зохион байгуулж, нийт албан хаагчид хамрагдаж, сертификат гардан авсан.

Байгууллагын хэмжээнд 3 албан хаагчийн ар гэрийн гачигдалд зориулан 1,400.000 төгрөгийг дотоод журмын дагуу олгосон.

Нийт албан хаагч нарын 2019 оны ээлжийн амралтыг гарган батлуулж, мөн хоолны мөнгөний нэмэгдлийн талаар байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд тусган мөрдөн ажиллаж байна.

Энэ жил улсын хэмжээнд зохион байгуулсан Архивын улсын үзлэгт байгууллага, хамт олноороо амжилттай сайн бэлтгэж 88 хувийн амжилттай дүгнэгдсэн.

ERP програмыг үйл ажиллагаандаа тогтмол ашиглаж хэвшсэн бөгөөд ерг цаг ашиглалтын төхөөрөмжийг шинээр суурилуулан, ашиглаж байна. Ирсэн, явсан албан бичгийг бүртгэн, шийдвэрлэх хугацаанд хяналт тавьж, жилийн эцсийн байдлаар ирсэн 119 албан бичгийг шийдвэрлэн ажилласан. Хугацаа хэтрүүлж шийдвэрлэсэн албан бичиг байхгүй, мөн шийдвэрлэсэн бичгийн хяналтыг цаг хугацаанд нь хааж ажилласан.

Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдолын талаар

Тайллангийн хугацаанд иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдол байхгүй болно.

Дөрөв. Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдал

Ил тод байдлын хуулийн хүрээнд байгууллагын шилэн дансанд санхүүгийн мэдээ, тайланг хуулийн хугацаанд тогтмол байршуулан тайлагнан ажилласан. Байгууллагын мэдээллийн самбарт сар бүр төсвийн зарцуулалтын мэдээ тайланг байршуулсан ба вэб сайтанд санхүүгийн мэдээ, тайланг тухай бүр нь байршуулж ажилласан.

Ажиллагсдын үндсэн болон нэмэгдэл, нэмэгдэл шагнал урамшуулал, хоол унааны хөнгөлөлт зардал болон бусад нөхөн олговрын хэмжээг хөдөлмөрийн гэрээгээр зохицуулж, өмнөх онд хүрсэн түвшингээс бууруулахгүй ажилласан. Албан хаагчдын ур чадварын нэмэгдэл болон үр дүнгийн нэмэгдлийг холбогдох журмын дагуу олгосон.

Байгууллагын веб сайтыг тогтмол ажиллагаанд оруулсан бөгөөд даргын А тушаал, Хөдөлмөрийн дотоод журам болон Ёс зүйн журмыг байршуулсан. Байгууллагын үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомжийг цахим хаягтаа бүрэн байршуулсан ба төсөл хөтөлбөрийн хэрэгжилт, үйл ажиллагааны талаархи явцын мэдээллийг цахим хуудсандaa байрлуулан ажилласан болно. Ажлын байрны сүл орон тооны зарыг мэдээллийн самбар, веб сайт болон бусад олон нийтийн мэдээллийн хэрэгсэл ашиглан байрлуулж, ХААИС болон бусад мэргэжлийн байгууллагад санал тавьж ажилласан ба 2019 оны 1 дүгээр сард хөдөө аж ахуйн механик инженер мэргэжилтэй иргэн Бат-Эрдэнийг Механикийн орон тоон дээр ажилд авсан. Мөн албан хаагчдын ажлын Үр дүнгийн шагнал олгох болон Үр чадварын нэмэгдэл олгох журмыг боловсруулан даргын тушаалаар батлуулж, байгууллагын цахим сайтад байрлуулан ажиллаж байна.

Тав. Бусад

Байгууллагын СХД-ийн 21 дүгээр хороо, Нарийний хөндийн Шар хоолойн аманд байрлах эрчимжсэн 90 үнээний аж ахуй, сургалтын төв байрлах 1 га талбайн тохижилтын ажлыг гүйцэтгэж, цэцэрлэгжүүлэлт, зүлэгжүүлэлт хийж, явган хүний зам талбай засч, хогийн цэгийн ойр орчмын талбайг цэвэрлэсэн. Чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор байгууллагаас хөрөнгө гаргаж, сагсны шийд худалдан авч, суурилуулсан. Фермийн аж ахуйн хашаанд 500 000 төгрөгний /үүнээс албан хаагчид 200000 төгрөгийг өөрсдийн цалингаас гаргасан/ өртөг бүхий 130 мод сөөг нэмж тарьсан. Үүнд: 103 ширхэг хайлаас, 3 гацуур, 2 өрөл, 20 чацааргана, 3 үхрийн нүд. Мөн өмнөх жилийн тарьсан мод сөөгний арчилгааг хийж, цэцэг тарьж, хашаан доторх зарим хэсгийг зүлэгжүүлэх зэрэг ажлуудыг хамт олноороо хийж гүйцэтгэсэн.




1.3 за мінімальну вагу бородавкового яблука вага 10 кг

Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан СХД-ийн 21 дүгээр хорооны Нарийний багийн иргэн, өрх толгойлсон эмэгтэйд байгууллагын ажилчдын гарын бэлгийг гардуулсан.



Байгууллагын 1.5 га талбайд боловсруулалт хийж, 0,4 га-д төмс, 0,6 га-д шар лууван, хүрэн манжин, шар манжин, урт сонгино тариалж арчилгаа, усалгааны ажлыг гүйцэтгэсэн. Төмс 1800 кг-ыг хураан авсан.



1.5 га талбайд хөрс боловсруулалт хийж байгаа нь



/Зооринд хадгалсан үрийн төмсөнд ялгалт хийж, НХХААГ-т 2.5 тн үрийн төмсийг хүлээлгэн өгөв./

**ХЯНАСАН: ДАРГА
БОЛОВСРУУЛСАН: МЕНЕЖЕР**



**/Г.ГАЛДӨЛ/
/Г.ПҮРЭВСҮРЭН/**